



МОНГОЛ
ДУНДГОВЬ
ЖЕНДЭРИЙН
КЛУБЫН
2021 ОНЫ
АЖЛЫН
МЭДЭЭЛЭЛ

ДУНДГОВЬ ЖЕНДЭРИЙН КЛУБЫН 2021 ОНЫ АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

Илтгэгч А.НАРАНТУЯА

Танилцуулгын хүрээ:


- ❖ Жендэрийн клубын гишүүдийн ур чадвар, клубын үйл ажиллагааны өргөжилт
- ❖ Жендэрийн тэгш байдлын талаар төрийн албан хаагчид, олон нийтийн ойлголт
- ❖ Жендэрийн мэдрэмжтэй бодлого, хөтөлбөрийн баримт бичиг

Зорилт 1. Жендэрийн клубын гишүүдийн ур чадвар сайжирч, клубын үйл ажиллагаа өргөжиж байна.

- Жендэрийн клубын гишүүдэд төрийн бус байгууллагын төлөөлөл болон зарим төрийн байгууллагаас гишүүд шинээр орж ирж өргөжлөө.
- Аймгийн хүний эрхийн үндэсний комиссын референттэй хамтран клубын 12 шинэ гишүүддээ “Жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах нь” сургалтыг зохион байгууллаа.



Зорилт 1. Жендэрийн клубын гишүүдийн ур чадвар сайжирч, клубын үйл ажиллагаа өргөжиж байна.



- “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт”, “Жендэрийн сургагч багш бэлтгэх” анхан шатны сургалтад клубын 3 гишүүнийг хамруулж чадавхжууллаа.
- Мөн “Хүчирхэг илтгэл” буюу “Олон нийтийн өмнө үг хэлэх, илтгэх урлаг” сэдэвт 2 өдрийн онлайн сургалтанд 4 албан хаагч хамрагдсан.

Зорилт 1. Жендэрийн клубын гишүүдийн ур чадвар сайжирч, клубын үйл ажиллагаа өргөжиж байна.

- Салбар хоорондын уялдааг хангах, салбаруудын санаачлагыг дэмжихэд түлхүү анхаарч ажиллалаа.
- Жендэрийн клубын гишүүд орон нутгийн хэмжээнд төсөл, хөтөлбөр болон хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох уулзалт, бүтээлч ажлуудыг санаачлан хийж хэрэгжүүлж байна.

Зорилт 1. Жендэрийн клубын гишүүдийн ур чадвар сайжирч, клубын үйл ажиллагаа өргөжиж байна.

Жендэрийн клубын гишүүн аймгийн эмэгтэйчүүдийн холбооны дарга Т.Алимаагийн санаачлагаар аймгийн удирдлагууд эмэгтэйчүүдийг хүлээн авч “Орон нутгийн хөгжилд- эмэгтэйчүүдийн оролцоо ба нөлөөлөл” сэдэвт уулзалтыг зохион байгууллаа.

Уулзалтанд оролцогчид хүний хөгжил, иргэдийн боловсрол соёлын талаарх асуудлыг дэвшүүлж “ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ НЭГДЭЦГЭЭЕ” уриалгатайгаар уулзалтын арга хэмжээг өндөрлүүллээ.



Зорилт 1. Жендэрийн клубын гишүүдийн ур чадвар сайжирч, клубын үйл ажиллагаа өргөжиж байна.

- НҮБХХ-ийн хэрэгжүүлсэн “Ковид-19 нийгэм эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах, салбар хоорондын уялдаатай, хүртээмжтэй хариу арга хэмжээг дэмжих” үндэсний туршилтын төсөлд хамтран хэрэгжүүлэгчээр оролцож амжилттай хэрэгжүүллээ.
- Төслийн зорилго: Онцгой нөхцөл байдалд нутгийн удирдлагын анхан шатны \хороо, сум\ түвшинд хэрэглэх боломжтой шуурхай, нийгмийн үйлчилгээний салбар хоорондын уялдааг хангасан хариу арга хэмжээ авах дэвшилтэт техник технологи, инновацид тулгуурласан шийдэл нэвтрүүлэх
- Төслийн үр дүн: Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Нийгмийн ажилтны систем”- ийг хөгжүүлэн, үндэсний хэмжээнд нэвтрүүлсэн.

Зорилт 1. Жендэрийн клубын гишүүдийн ур чадвар сайжирч, клубын үйл ажиллагаа өргөжиж байна.

- “Нийгмийн ажлын инноваци” төслийн уралдаанд амжилттай оролцож шалгаран “Халамжаас - хөдөлмөрт” төслийг хэрэгжүүлсэн.
- Төслийн бүрэлдэхүүнд ажилласан.
- Төслийн зорилго: Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, байнгын болон түр ажлын байранд ажиллуулах



Зорилт 1. Жендэрийн клубын гишүүдийн ур чадвар сайжирч, клубын үйл ажиллагаа өргөжиж байна.



Төслийн инновац:

Нийгмийн ажилтны санаачлагаар зорилтот бүлгийн иргэдийн хүсэл сонирхолд тулгуурлан тэдний хөгжил, оролцоог ханган, эргэх холбоог сайжруулан ажиллаж, харилцааны хүрээг тэлснээр иргэн, нийгмийн ажилтан, аж ахуйн нэгжийн уялдаа холбоо сайжирч, үйлчилгээний болон арга барилын инновацыг бий болгосон.

Зорилт 1. Жендэрийн клубын гишүүдийн ур чадвар сайжирч, клубын үйл ажиллагаа өргөжиж байна.



Төслийн оролцогч:

- 23-35 хүртэлх насны залуучууд
- Төрөөд гэртээ хүүхдээ харж байгаа эхчүүд
- Мэргэжлийн боловсрол эзэмшсэн мөртлөө ажилгүй хөдөлмөр эрхлээгүй залуучууд

Зорилт 1. Жендэрийн клубын гишүүдийн ур чадвар сайжирч, клубын үйл ажиллагаа өргөжиж байна.



Төслийн үр дүн:

- Байнгын ажлын байранд 3 иргэн
- Түр ажлын байранд 3 иргэн
- Дадлагажих сургалтанд 7 иргэн тус тус хамрагдсан.



Зорилт 1. Жендэрийн клубын гишүүдийн ур чадвар сайжирч, клубын үйл ажиллагаа өргөжиж байна.



© CanStockPhoto.com - csp28191205

Төслийн үр дүн:

Мэргэжил олгох сургалтанд
буюу МСҮТ-ийн 2021-2022
оны хичээлийн жилийн
элсэлтэд

- Оёдолын ангид 3 иргэн
- Үсчин болохоор 1 иргэн тус тус элсэн суралцаж байна.


Зорилт 2: Жендэрийн тэгш байдлын талаар төрийн албан хаагчид, олон нийтийн ойлголт сайжирсан байна.

- Ахисан шатны жендэрийн сургалтад 400 гаруй албан хаагчдыг хамруулж, сертификатаар баталгаажуулаад байна.
- Аймгийн 8 сумын 24 албан хаагчид жендэрийн мэдлэг олгох сургалтыг 10 сарын 25-наас 30-ны хооронд газар дээр нь очиж зохион байгууллаа.



Зорилт 2: Жендэрийн тэгш байдлын талаар төрийн албан хаагчид, олон нийтийн ойлголт сайжирсан байна.

- Эрүүл мэндийн подкастаар Аймгийн Нэгдсэн эмнэлэгийн Эх барих эмэгтэйчүүдийн их эмч У.Буянжаргал-тай "Залуучуудын бэлгийн боловсрол, БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх" сэдвээр сонирхолтой ярилцлагыг зохион байгууллаа.
- Гэр бүл судлаач Ж.Баясгалантай “Эхнэр нөхрийн зан чанар, сэтгэл зүйн онцлог” сэдэвт подкастийг зохион байгуулж, Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын пэйж хуудсанд байршуулж, иргэд олон нийтэд түгээж ажиллалаа.



Зорилт 2: Жендэрийн тэгш байдлын талаар төрийн албан хаагчид, олон нийтийн ойлголт сайжирсан байна.

СЭТГЭЛ ЗҮЙН ЛЕКЦ

Урилгаар:
Гэр бүл,
Сэтгэл судлалын
ухааны доктор
Г. НАРАНБААТАР



- 1 Хүрсэнээс минь илүү өндөр!
/Хүн болгон хүүхдэдээ хамгийн сайхныг хүсдэг нь үнэн.
Гэхдээ та хамгийн сүүлд хэзээ хүүхэд хүмүүжлийн
сургалтад суусан бэ? Та хүүхдийнхээ төлөө өөр бүсэд
ажлыг хойш тавин ирэх хүсэл "авч ээж" танд байгаа бол уу?
- 2 Мэдээлэл боловсруулах, дамжуулах арга техник
/багш, сургуулийн ажилчид/
- 3 Хандлагын өндөр ямар байна Амжилтын өндөр тийм байна.
/+13 Өсвөр залуучууд/

Хүүхдүүд маань онц сайн сурахаас илүүтэйгээр онц сайн хүмүүжиж
өнөөгийн бидний нийгмээс илүү хүнлэг, илүү сайхан нийгмийг бүтээж
амьдрахад нь бүгд хамтдаа оролцоотой байж дэмжлэг үзүүлцгээе

Хүүдговь аймгийн
998 оны төгсөгчид

Хэзээ. 2021.11.11-12 Хаана. Төв халхын дуулалт жүжгийн театр

ГЭР БҮЛ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН УХААНЫ
ДОКТОР Г. НАРАНБААТАРЫГ УРЬЖ ХОЁР
ӨДРИЙН ИЛТГЭЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.


Эцэг эхчүүдэд хүүхдийн хүмүүжил, өсвөр
үеийн сурагчдад амжилттай суралцах
боломж хандлага, багш нарт мэдээлэл,
боловсруулах, дамжуулах арга техник зэрэг
сэдвүүдээр нийтдээ 8 удаа зохион байгуулж
1600 гаруй ерөнхий боловсролын сургуулийн
ахлах ангийн сурагчид болон багш, эцэг
эхчүүдийг оролцуулж оролцоог хангалаа.



Зорилт 2: Жендэрийн тэгш байдлын талаар төрийн албан хаагчид, олон нийтийн ойлголт сайжирсан байна.

"Ажлын байран дахь стрессийг даван туулах нь" сэдвээр сэтгэл зүйч Г.Отгонсүрэн "Butterfly" подкаст ярилцлага зохион байгууллаа.

Стрессийг даван туулах, амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэндийн талаарх ойлголт, мэдлэг түгээх сургалт, зөвлөгөө өгөх "Ажлын байрны стрессийг даван туулах нь" подкастыг бэлтгэн цахимаар 1725 хүнд хүргээд байна.



Зорилт 2: Жендэрийн тэгш байдлын талаар төрийн албан хаагчид, олон нийтийн ойлголт сайжирсан байна.

Эрэгтэйчүүдийн физиологи, бие бялдрын хувьд эрүүл, илүүдэл жингүй байх уриалга, арга хэмжээг үндэсний хэмжээнд зохион байгуулах зорилгоор Аймгийн хэмжээнд өглөөний алхалт, Дугуйгаар хичээллэгсдийн тоо өдрөөс өдөрт нэмэгдэж 1645 гишүүнтэй болсон байна.



Зорилт 2: Жендэрийн тэгш байдлын талаар төрийн албан хаагчид, олон нийтийн ойлголт сайжирсан байна.

- "АМЬДРАЛЫН ЭРҮҮЛ ДАДАЛ ХЭВШИЛ, ДАСГАЛ ХӨДӨЛГӨӨН" сэдвээр "Голден жим" финнес клубын Сургалт хариуцсан захирал Ө.ДОЛГОРМАА сургалт зохион байгууллаа.
- Аймгийн Цагдаагийн газар албан хаагчдынхаа дунд илүүдэл жингээ хасах, эрүүлжих уралдаан зарлаж үр дүнгээ тооцлоо.



Зорилт 2: Жендэрийн тэгш байдлын талаар төрийн албан хаагчид, олон нийтийн ойлголт сайжирсан байна.

ДУНДГОВЬ АЙМАГ ДУНДАЖ НАСЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ

□ЭРЭГТЭЙ: 71.4

□ЭМЭГТЭЙ: 79.0

ДУНДАЖ НАСЛАЛТААР
МОНГОЛ УЛСАД ТЭРГҮҮЛЖ
БАЙНА.



Зорилт 3. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, хөтөлбөрийн баримт бичиг батлагдсан байна.

- Аймгийн Засаг даргын Сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээнд жендэрийн ахисан түвшний сургалтанд төрийн албан хаагчдыг бүрэн хамруулна гэсэн заалтыг оруулсан.
- Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт сэдвээр 8 сумын Жендэрийн дэд зөвлөлийн 51 гишүүддээ 1 цагийн сургалтыг зохион байгууллаа.



Зорилт 3. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, хөтөлбөрийн баримт бичиг батлагдсан байна.


Ахисан шатны жендэрийн сургалтыг 15 сумдын Засаг даргын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 6.1.1 дэх заалт болон ТЖАХ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, сургалтад 400 гаруй албан хаагч хамрагдаж сертификатаа авсан байна.




Зорилт 3. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, хөтөлбөрийн баримт бичиг батлагдсан байна.

Хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр заалтыг хөдөлмөрийн дотоод журамд тусгасан.

- 12 сумын ЗДТГ болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 19 байгууллагад Хүний эрхийн үндэсний комиссын орон нутгийн референттэй хамтран явцын хяналт хийж зөвлөн туслаж боловч бүрэн утгаар нь тусгаагүй зөрчлүүд 70 хувийг эзэлж байгааг залруулах арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.



Зорилт 3. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, хөтөлбөрийн баримт бичиг батлагдсан байна.



MERIT төслийн санхүүжилтээр Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газарт хэрэгжсэн ISO 9001:2015 олон улсын чанарын менежментийн тогтолцооны дахин баталгаажуулалтын аудитад бэлтгэх сургалт, зөвлөх үйлчилгээг авч байна.

Уг зөвлөх үйлчилгээг Монголын чанарын менежментийн зөвлөхүүдийн холбооны ахлах зөвлөх Б.Энхнавч удирдаж ажиллаж байна. Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад “ӨНДӨР БҮТЭЭМЖТЭЙ АЖЛЫН ОРЧИНГ БИЙ БОЛГОХ НЬ” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

*Анхаарал
хандуулсанд
баярлалаа*

